

ЯАРАЛТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ӨВӨР МОНГОЛД ТАЙВАН ЗАМААР ЭСЭРГҮҮЦЭГЧИД ХАВЧЛАГАД ӨРТӨӨД БАЙНА

Хятадын хойд нутаг дахь Өвөр Монголын Өөртөө Засах Оронд “хос хэлний боловсролын бодлого”-ыг эсэргүүцэн тайван жамаар жагссан, эсэргүүцлийн талаарх мэдээлэл түгээснийх нь төлөө хамгийн багадаа 23 хүнийг “үймээн дэгдээж, хэв журам зөрчсөн” гэх хэргээр баривчилжээ. 2020 оны 9 дүгээр сарын 2-нд Тунляо хотын Хорчин дүүргийн цагдаа нар “үймээн дэгдээж, хэв журам зөрчсөн” гэх хэрэгт сэжиглэгдэж байгаа 129 хүний нэрийг нийтэлсэн байна. Баривчлагдсан хүмүүс хаана байгаа тухай эрх баригчид мэдээлэхгүй байна. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхээ эдэлснийхээ төлөө хэн ч баривчлагдах ёсгүй.

ТА ДАРААХЬ ЗАГВАР ЗАХИДЛЫГ ИЛГЭЭХ БУЮУ ЭСВЭЛ ӨӨРИЙН ҮГЭЭР ЗАХИДАЛ УРИАЛГА БИЧИЖ ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРНҮҮЛНЭ ҮҮ.

Дарга Хөнг Шиаофан
Өвөр Монголын Өөртөө засах орны Олон нийтийн Аюулгүй байдлын газар
Но. 15, Хайлаар Дон лу,
Шинчен дүүрэг, Хөххот
010020, Өвөр Монголын Өөртөө Засах Орон
Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Эрхэм Дарга Хөнг Шиаофан:

2020 оны 9 дүгээр сарын эхээр Өвөр Монголд тайван замаар эсэргүүцлээ илэрхийлсэн хүмүүсийг хавчин мөрдөж байгаад би санаа зовниж байгаагаа илэрхийлж байна.

Хэвлэлийн мэдээгээр “хос хэлний боловсролын бодлого”-ыг тайван замаар эсэргүүцсэн, энэ талаарх мэдээллийг түгээснийхээ төлөө дунд сургуулийн сурагч, жирэмсэн эмэгтэй зэрэг нийт 23 хүн “үймээн дэгдээж, хэв журам зөрчсөн” гэх хэргээр баривчлагджээ.

2020 оны 9 дүгээр сарын 2-нд Тунляо хотын Олон нийтийн Аюулгүй байдлын Товчооны Хорчин дүүргийн салбар “үймээн дэгдээж, хэв журам зөрчсөн” гэх 129 хүний нэр, фото зургийг хэвлэн гаргасан байна.

Тайван замаар эсэргүүцлээ илэрхийлсэн, энэ талаарх мэдээллийг бусадтай хуваалцсных нь төлөө хэн нэгнийг баривчлан, яллах нь олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар жагсаал цуглаан хийх эрхийг зөрчиж байна.

Мөн баривчлагдсан хүмүүсийн хаана байгааг олон нийтэд мэдэгдэхгүй байгаа нь сэтгэл ихээр түгшээж, тэднийг эрүүдэн шүүж, зүй бус харьцах вий хэмээн санаа зовниход хүргэлээ.

Иймд би танаас:

- Тайван замаар эсэргүүцлээ илэрхийлсэн тэдгээр хүмүүсийг олон улсын хэм хэмжээнд нийцсэн шударга шүүхээр шүүж, олон улсад гэмт хэрэг хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн хэрэг үйлдсэн гэх хангалттай үнэмшилтэй, хүлээн зөвшөөрөхүйц нотолгоо байхгүй бол нэн даруй, ямар нэг нөхцөлгүйгээр суллах;***
- Цаашид тайван замаар жагсааж, цуглах эрхээ эдэлснийх нь төлөө хүмүүсийг баривчилж, яллахаас татгалзах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хүсч байна.***

Гүнээ хүндэтгэсэн,

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Өвөр Монголын Өөртөө Засах Орон(Өвөр Монгол)-д 9 жилийн ерөнхий боловсролын сургуулийн Монгол хэлээр заадаг байсан хичээлүүдийг Хятад (мандарин) хэлээр заах өөрчлөлт оруулсан “хос хэлний боловсролын бодлого”-ыг эсэргүүцсэн хөдөлгөөн 2020 оны 9 дүгээр сарын эхээр өрнөсөн. Энэ шинэ бодлого 2020 оны 9 дүгээр сарын 1-нээс “хэл бичиг ба уран зохиол”-ийн хичээлээр эхэлсэн. Энэ төлөвлөгөөний дагуу цаашид Өвөр Монголын сургуулиуд 2022 оноос төрөөс эмхэтгэн гаргасан сурах бичигт үндэслэн хэл бичиг ба уран зохиол, түүх, ёс суртахуун ба хууль эрх зүй(улс төр)-н хичээлээ зөвхөн Хятад хэл дээр сурах юм байна. Энэ нь Өвөр Монголын хэл, соёлыг хавчих болно хэмээн шинэ бодлогыг эсэргүүцэгчид санаа зовниж байгаа юм.

Өвөр Монголын хүн амын ойролцоогоор 80% нь Хятадын хан үндэстэн бөгөөд 4,2 сая нь Монгол үндэстэн бөгөөд Хятадын нийт Монгол угсаатан хүн амын 70% орчмыг эзэлдэг.

Хятадын эрх баригчид хэвлэмэл болон цахим бүх хэвлэл мэдээллийг чанд хатуу хянадаг тул эсэргүүцэгчид үйл ажиллагаагаа баримтжуулсан мэдээллээ бусадтай хуваалцахад бэрхшээлтэй байдаг. Хятад улсад байгаа гадаадын сэтгүүлчид тус улсын талаарх мэдээллийг түгээхэд цөөнгүй хязгаарлалт, хориглолттой тулгардаг. Эсэргүүцлийн үеэр Өвөр Монголын нийслэл Хөх хотын Монгол хэлний сургуулиар орсон *Лос Анжелес Таймс*-ийн сурвалжлагчийг энгийн хувцастай хүмүүс бүчин авч, тус сургуулийн хойно байрлах цагдаагийн газарт авчирчээ. Тус сэтгүүлч өөрийгөө албан ёсны эрхтэй сурвалжлагч гэдгийг мэдэгдсэн ч түүнийг байцааж, эд зүйлийг нь хураан авчээ. Дөрвөн цаг гаруй хорьсны эцэст сэтгүүлч эмэгтэйг ӨМӨЗО-оос албадан гаргасан байна.

Маш олон хэвлэл мэдээллийн хэрэгслээр Өвөр Монголд орон нутгийн захиргааны зарим албан хаагчид, багш нар, Коммунист намын гишүүд шинэ “хос хэлний боловсролын бодлого”-ыг хэрэгжүүлээгүйн улмаас шийтгүүлсэн тухай дурджээ. 9 дүгээр сарын 16-ны өдөр Шилийн хотын удирдлагууд сурагч, тэдний эцэг эхчүүдэд хандан хүүхдүүдээ цаг хугацаандаа сургуульд нь оруулахгүй бол засгийн газраас тусламж дэмжлэг олгохгүй байх, банкны зээлийг нь буцаалгах зэргээр шийтгэл оногдуулна хэмээн мэдэгдсэн байна.

Хятадын Эрүүгийн хуулийн 293 дугаар зүйл “үймээн дэгдээж, хэв журам зөрчсөн” (寻衅滋事罪) гэх гэмт хэрэг нь хүний эрх хамгаалагч, идэвхтнүүдийн эсрэг өргөнөөр хэрэглэгддэг, өргөн хүрээг хамарсан тодорхой бус хэрэг юм. Хэдийгээр энэ гэмт хэргийг олон нийтийн газарт хэв журам зөрчсөн үйлдэлд хэрэглэж байсан ч 2013 оноос эхлэн цахим орчныг хамруулан хэрэглэх хүрээг өргөжүүлжээ. Энэ хэрэгт буруутгагдсан бол дээд тал нь 5 жилийн хорих ялаар шийтгүүлэх юм.

ЭРХ БАРИГЧ НАРТ ХАНДСАН ЗАХИДАЛ УРИАЛГАА ХЯТАД, АНГЛИ ХЭЛЭЭР БИЧНЭ ҮҮ.

Мөн та өөрийн улсын хэлээр бичиж болно.

ЯАРАЛТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭН ДАРУЙ ЭХЛҮҮЛЖ, 2020 ОНЫ 11-Р САРЫН 21 ХҮРТЭЛ ЯВУУЛАХ БОЛОМЖТОЙ

Энд заасан хугацаанаас хойш захидал уриалга илгээх бол та өөрийн улсад байгаа Эмнести Интернэшнлийн салбартай холбогдоно уу.

NAME AND PRONOUN: Group (they/them)